



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/413

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны 6 дугаар тогтоолын хавсралтын 2.1.6, 2023 оны 3-р сарын 09-ний "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" арваннаймдугаар хуралдааны 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй улсын аварга шалгаруулах адуучин тэмцээнийг Баянхутаг суманд зохион байгуулахад 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ